



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ тогтоох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.4 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.6 дугаар заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ШУТИС-ийн 2017-2018 оны хичээлийн жилийн бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг өмнөх хичээлийн жилийн сургалтын төлбөрийг нэмэгдүүлэхгүйгээр хавсралтын дагуу мөрдсүгэй.

2. Магистрантурын сургалтын нэг кредитийн үнэлгээг бакалаврын сургалтын батлагдсан нэг кредитийн үнэлгээг 1.5 дахин нэмэгдүүлж тогтоосугай.

3. Докторантурын сургалтын нэг кредитийн үнэлгээг бакалаврын сургалтын батлагдсан нэг кредитийн үнэлгээг 2.0 дахин нэмэгдүүлж тогтоосугай.

4. ШУТИС-д хэрэгжүүлж байгаа гадаадын их, дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийн гадаад хэл дээр заагдаж байгаа хичээлийн нэг кредитийн үнэлгээг бакалаврын сургалтын батлагдсан нэг кредитийн үнэлгээг 2.0 дахин нэмэгдүүлж тогтоосугай.


5. ШУТИС-ийн бүрэлдэхүүн Шинжлэх ухаан технологийн ахлах сургууль, Коосен загварын технологийн дээд сургуулийн 2017-2018 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийг өмнөх оноос нэмэгдүүлэхгүйгээр 3,000,000 (гурван сая) төгрөгөөр тогтоосугай.

6. Сургалтын төлбөрийг дээд боловсролын салбарт баримталж буй бодлоготой нийцүүлэн тогтоосонтой холбогдуулан 2018 оны улсын болон нийслэлийн төсвийн төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг тусган батлуулах талаар идэвх санаачлагатай ажиллахыг сургуулийн удирдлагад үүрэг болгосугай.

ДАРГА



Н.БЭГЭ



ШУТИС-ийн 2017-2018 оны хичээлийн жилд мөрдөх нэг кредитийн үнэлгээ

№	БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИЙН НЭР	НЭГ КРЕДИТИЙН ҮНЭЛГЭЭ /төгрөг/	
		2015 оноос хойш элсэн суралцагчид	2015 оноос өмнөх элсэн суралцагчид
1	БАРИЛГА АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬ	62875	57845
2	БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ	66250	60950
3	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ	62875	57845
4	ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ	62875	57845
5	МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ	66250	60950
6	ЭРЧИМ ХҮЧНИЙ СУРГУУЛЬ	64375	59225
7	МЕХАНИК ТЭЭВРИЙН СУРГУУЛЬ	62875	57845
8	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ	57875	53245
9	ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ	56750	52210
10	ГАДААД ХЭЛНИЙ ИНСТИТУТ	55125	50715
	ШУТИС-ийн дундаж үнэлгээ	61813	56868

--- 000 ---



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Оюутны байрны төлбөр тогтоох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.4 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.6 дугаар заалт, Удирдах зөвлөлийн 2017 оны 06-р сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:


1. ШУТИС-ийн 2017-2018 оны хичээлийн жилд мөрдөгдөх оюутны байрны төлбөрийг өмнөх хичээлийн жилийн оюутны байрны төлбөрийг нэмэгдүүлэхгүйгээр хавсралтаар баталсугай.

2. Оюутны байрны орчин, нөхцөлийг сайжруулах талаар дэс дараатай арга хэмжээг авч ажиллахыг ШУТИС-ийн удирдлага, холбогдох албан тушаалтанд үүрэг болгосугай.

ДАРГА



Н.БЭГЗ



ШУТИС-ийн 2017-2018 оны хичээлийн жилд мөрдөх нэг кредитийн үнэлгээ

СУРГУУЛ Ь	Өрөөний багтаамж, зориулалт	Сарын төлбөрийн хэмжээ (мян.төг)		
		Нэг оюутан	Нэг айл өрх /цахилгааны төлбөр орохгүй/	Оюутнаас авах барьцаа /жилд/
БУХС	2 хүний	55.0	170.0	30.0
	4 хүний	40.0	200.0	30.0
ДТС	4 хүний	40.0	-	30.0
МТС	4 хүний	40.0	200.0	30.0
МХТС	4 хүний	45.0	120.0	30.0
ҮТС	4 хүний	40.0	200.0	30.0
	1 хүний люкс	264.0		
	2 хүний люкс	234.0		
	2 хүний энгийн	216.0		

--- 0 0 0 ---